

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Усны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/244/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Э.Энхбаатар
Утас: 260512 Цахим хаяг: Enkhbaatare@audit.gov.mn
Ахлах аудитор: О.Баярмаа
Утас: 260512 Цахим хаяг: bayarmaao@audit.gov.mn
Мишээл-Од Аудит ХХК-ийн захирал: Т.Одончимэг
Утас:70169029 Цахим хаяг: info@misheelodaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	15
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	15
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	16
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	16
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
4. АУДИТЫН ТАЙЛАН	23
4.1 Ерөнхий зүйл	23
4.2 Материаллаг байдал	23
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	23
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	23
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	25
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	26
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	27
5.1 Төлбөрийн акт	28
5.2 Албан шаардлага	28
5.3 Зөвлөмж	29
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	31

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОУАӨС	Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн сайд
БОУАӨЯ	Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам
ЗГ	Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
МУ	Монгол улс
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОХУ	Оросын холбооны улс
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



УСНЫ ГАЗРЫН ДАРГА
З.БАТБАЯР ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/388
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Усны газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг үндэслэлтэй төлөвлөөгүй, тодотголоор нэмэгдүүлээгүйгээс үйл ажиллагааны орлого 82.7 хувь буюу 671,169.1 мянган төгрөгөөр давж биелсэн;
- Тайлант хугацаанд 64 харилцагчид 92,309.9 мянган төгрөгийн борлуулалтын төлбөрийн баримт илүү, орлогын гүйлгээ хийгээгүй 48 харилцагчид 33,589.9 мянган төгрөгийн баримтыг үндэслэлгүйгээр төлбөрийн баримтын цахим системд шивж олгосон;
- Итали улсад зохион байгуулагдсан "Усны үнэ цэнэ хурал"-д оролцсон Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 2 албан хаагчид 16,423.9 мянган төгрөгийн зардал гаргасан зэрэг нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 22 дугаар зүйл 22.6, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.1.9, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2, 17.3, 17.3.1,

17.3.2, 17.5 дахь заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

“Эгийн голын усан цахилгаан станц” төслийн Сэлэнгэ мөрний сав газрын экосистемд үзүүлэх өөрчлөлтийг тодорхойлох судалгааны ажил гүйцэтгүүлэхээр 1,519,975.4 мянган төгрөгийн шууд гэрээ байгуулан 820,000.0 мянган төгрөгийн урьдчилгааг шилжүүлсэн, судалгааны ажилд ашиглах багаж, тоног төхөөрөмж, програм хангамжийг 380,045.0 мянган төгрөгөөр худалдан авч хүлээлгэн өгөөгүй үндсэн хөрөнгөнд бүртгэж, 9,658.9 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулсаныг залруулсан.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Усны нөөцөд учруулсан хохирлын нөхөн төлбөрт 44 харилцагчид 9,266,742.0 мянган төгрөгийн төлбөр ногдуулснаас 8,656,518.4 мянган төгрөгийн төлбөр төлөгдөөгүй, Усны нөөц ашигласны төлбөрийг 308 байгууллагад 119,814,399.2 мянган төгрөгийн ногдуулалт хийснээс 22,708,175.5 мянган төгрөг дутуу төвлөрсөн, 50 байгууллагатай гэрээ дүгнээгүй дараа оны ногдуулалт хийсэн нь холбогдох журмыг зөрчсөн, Ус бохирдуулсны төлбөрт 252 дүгнэлтээр 11,121,090.2 мянган төгрөгийн төлбөр тооцоолж, 9,124,633.2 мянган төгрөгийг чөлөөлж, 105 харилцагчийн 327,520.9 мянган төгрөгийн төлбөр төвлөрөөгүй байгаа зэрэг нийт 31,692,214.8 мянган төгрөгийн төлбөрийн биелэлтэд тавих хяналт хангалтгүй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.”Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын 35 хувийг байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах” гэж заасан боловч усны төлбөрийн орлогын 9.0 хувьтай тэнцэх хөрөнгийг усны нөөц бохирдож хомстохоос хамгаалах, усны орчныг нөхөн сэргээхэд зарцуулж байна.

Бусад асуудал

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



C. Naranchimeg Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	87,742,604.29	1,209,418,782.03
33	АВЛАГА	14,538,639.29	695,980,252.03
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	4,538,639.29	3,172,195.53
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	21,638,956.50
33500	Бусад авлага	10,000,000.00	671,169,100.00
33510	Байгууллагаас авах авлага	10,000,000.00	671,169,100.00
34	УРЬДЧИЛГАА	9,500,000.00	-
34600	Урьдчилж гарсан зардал	9,500,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	63,703,965.00	513,438,530.00
35100	Түүхий эд материал	10,701,950.00	12,886,780.00
35110	Тусгай зориулалттай материал	10,701,950.00	12,886,780.00
35400	Хангамжийн материал	53,002,015.00	500,551,750.00
35410	Бичиг хэргийн материал	200,200.00	209,200.00
35420	Аж ахуйн материал	52,072,969.00	35,342,550.00
35440	Түлш, шатах тослох материал	728,846.00	-
35470	Бусад хангамжийн материал	-	465,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,263,244,062.72	3,499,929,371.70
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,263,244,062.72	3,499,929,371.70
39200	Биет хөрөнгө	3,021,944,962.80	2,809,086,816.86
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,269,061,506.18	1,511,438,369.18
39202	Хуримтлагдсан элэгдэл	(150,230,125.71)	(182,269,947.45)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	519,350,829.90	519,350,829.90
39204	Хуримтлагдсан элэгдэл	(186,211,528.09)	(265,712,725.69)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	2,372,831,041.38	1,920,620,046.76
39206	Хуримтлагдсан элэгдэл	(904,068,623.32)	(772,186,530.25)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	133,576,090.93	129,937,208.33
39208	Хуримтлагдсан элэгдэл	(32,364,228.47)	(52,090,433.92)
39300	Биет бус хөрөнгө	1,241,299,099.92	690,842,554.84
39301	Програм хангамж	3,879,666.86	3,879,666.86
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,160,583.06)	(1,936,516.58)
39303	Бусад биет бус хөрөнгө	2,803,261,710.00	2,803,261,710.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(1,564,681,693.88)	(2,114,362,305.44)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	4,350,986,667.01	4,709,348,153.73
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	1,494,983,369.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	1,494,983,369.00
41300	Өглөг	-	1,494,983,369.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	518,648.00
41360	Бусад өглөг	-	1,494,464,721.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,494,464,721.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,350,986,667.01	3,214,364,784.73
51	Засгийн газрын хувь оролцоо	4,350,986,667.01	3,214,364,784.73
51100	Засгийн газрын оруулсан капитал	257,921,878.13	257,921,878.13
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	257,921,878.13	257,921,878.13
51200	Хуримтлагдсан үр дүн	4,093,064,788.88	2,956,442,906.60
51210	Өмнөх үеийн үр дүн	5,196,911,306.01	4,093,064,788.88
51220	Тайлант үеийн үр дүн	(1,103,846,517.13)	(1,136,621,882.28)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	4,350,986,667.01	4,709,348,153.73

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	6,661,402,701.71	4,530,547,806.63
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	636,323,749.71	4,530,547,806.63
120	Нийтлэг татварын бус орлого	636,323,749.71	2,014,520,950.13
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	525,792,672.00	1,482,269,104.13
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	525,792,672.00	1,482,269,104.13
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	110,531,077.71	532,251,846.00
122	Тусламжийн орлого	-	2,516,026,856.50
1221	Хандив тусламж /дотоод/	-	2,516,026,856.50
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	70,377,956.50
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	70,377,956.50
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	70,377,956.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,025,078,952.00	2,445,648,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,553,381,711.00	2,445,648,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,553,381,711.00	2,445,648,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,471,697,241.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,471,697,241.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	7,204,561,105.70	5,484,774,728.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,204,561,105.70	5,484,774,728.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,720,349,413.86	5,361,859,137.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,088,761,507.65	1,334,323,365.04
210101	Үндсэн цалин	650,592,912.89	768,444,259.75
210102	Нэмэгдэл	143,371,293.00	197,370,265.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	181,114,000.00	263,304,963.00
210104	Урамшуулал	94,949,000.00	90,498,788.54
210105	Гэрээт ажлын хөлс	18,734,301.76	14,705,088.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	132,006,486.13	165,266,964.35
210201	Тэтгэврийн даатгалын зардал	86,820,004.28	113,575,391.34
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	10,864,301.46	12,713,025.83
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	9,254,741.71	10,800,638.44
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	5,013,487.78	5,635,561.90
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	20,053,950.90	22,542,346.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,013,349.86	42,818,916.07
210301	Гэрэл, цахилгаан	16,261,400.00	20,096,869.99
210302	Түлш, халаалт	13,745,849.86	8,384,777.61
210303	Цэвэр, бохир ус	14,006,100.00	5,427,268.47
210304	Байрны түрээс	-	8,910,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	79,538,181.47	74,344,182.00
210401	Бичиг хэрэг	15,118,400.00	10,976,500.00
210402	Тээвэр, шатахуун	32,371,460.00	19,782,246.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,548,399.83	6,615,362.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22,499,921.64	15,914,915.00
210408	Бараа материал акталсны зардал	-	21,055,159.00
2105	Нормативт зардал	68,926,120.00	98,465,588.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	68,926,120.00	98,465,588.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	119,718,490.00	17,850,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	89,019,790.00	6,997,150.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	12,710,700.00	1,330,050.00

Усны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210604	Урсгал засвар	17,988,000.00	9,523,000.00
2107	Томилолт, зочны зардал	52,894,700.00	48,826,600.00
210702	Дотоод албан томилолт	52,894,700.00	48,826,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,088,686,819.40	2,415,515,145.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,082,909,065.40	2,367,635,672.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	10,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	70,000.00	1,612,632.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	791,054.00	2,553,161.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	558,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,800,000.00	21,969,400.00
210807	Газрын төлбөр	-	1,161,280.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,116,700.00	10,025,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,045,803,759.35	1,164,448,176.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	41,416,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	4,360,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,044,803,759.35	1,118,671,576.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,484,211,691.84	122,915,591.43
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	37,716,485.60
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	37,716,485.60
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	37,716,485.60
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	37,716,485.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	899,390,823.56	85,199,105.83
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	44,156,883.56	80,199,105.83
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	855,233,940.00	5,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	584,820,868.28	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	479,119,227.28	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	105,701,641.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(543,158,403.99)	(954,226,921.80)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	560,688,113.14	182,394,960.48
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	3,792,800.00	-
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	480,819,313.14	182,394,960.48
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	76,076,000.00	-
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(560,688,113.14)	(182,394,960.48)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	(1,103,846,517.13)	(1,136,621,882.28)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	6,694,486,136.00	4,008,295,960.63
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	669,407,184.00	4,008,295,960.63
120	Нийтлэг татварын бус орлого	669,407,184.00	1,492,269,104.13
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	525,792,672.00	1,482,269,104.13
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	525,792,672.00	1,482,269,104.13
120009	Бусад орлого	143,614,512.00	10,000,000.00
122	Тусламжийн орлого	-	2,516,026,856.50
1221	Хандив тусламж /дотоод/	-	2,516,026,856.50
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	2,445,648,900.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	2,445,648,900.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	70,377,956.50
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	70,377,956.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,025,078,952.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,553,381,711.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,553,381,711.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,471,697,241.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,471,697,241.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,145,174,974.00	4,008,295,960.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,145,174,974.00	4,008,295,960.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,660,963,282.16	3,192,572,312.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,088,761,507.65	1,344,551,385.63
210101	Үндсэн цалин	657,245,192.00	741,830,726.86
210102	Нэмэгдэл	150,033,707.89	223,121,531.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	168,003,600.00	265,888,600.00
210104	Урамшуулал	94,744,706.00	98,913,195.77
210105	Гэрээт ажлын хөлс	18,734,301.76	14,797,332.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,545,125.42	153,672,500.00
210201	Тэтгэврийн даатгалын зардал	114,499,662.25	129,084,900.00
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	10,864,301.46	12,294,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	5,940,600.00	6,146,800.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	5,940,600.00	6,146,800.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	22,045,463.17	24,587,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,013,349.86	42,818,916.07
210301	Гэрэл, цахилгаан	16,261,400.00	20,096,869.99
210302	Түлш, халаалт	13,745,849.86	8,384,777.61
210303	Цэвэр, бохир ус	14,006,100.00	5,427,268.47
210304	Байрны түрээс	-	8,910,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	70,197,149.83	50,095,529.00
210401	Бичиг хэрэг	6,797,000.00	9,087,500.00
210402	Тээвэр, шатахуун	30,324,850.00	19,053,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,548,399.83	6,096,714.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	23,526,900.00	15,857,915.00
2105	Нормативт зардал	74,194,090.00	104,975,158.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	74,194,090.00	104,975,158.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	85,870,540.00	23,350,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	59,791,840.00	12,497,150.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	8,090,700.00	1,330,050.00
210604	Урсгал засвар	17,988,000.00	9,523,000.00
2107	Томиллолт, зочны зардал	52,894,700.00	48,826,600.00
210702	Дотоод албан томиллолт	52,894,700.00	48,826,600.00

Усны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,107,486,819.40	1,376,005,424.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,101,709,065.40	1,338,125,951.00
210803	Даатгалын үйлчилгээ	70,000.00	1,612,632.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	791,054.00	2,553,161.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	558,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,800,000.00	21,969,400.00
210807	Газрын төлбөр	-	1,161,280.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,116,700.00	10,025,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	48,276,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	43,916,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	4,360,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,484,211,691.84	815,723,647.93
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	730,524,542.10
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	730,524,542.10
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	730,524,542.10
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	708,885,585.60
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал\	-	21,638,956.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	899,390,823.56	85,199,105.83
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	44,156,883.56	80,199,105.83
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	855,233,940.00	5,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	584,820,868.28	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	479,119,227.28	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	105,701,641.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	549,311,162.00	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	405,696,650.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	405,696,650.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	405,696,650.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	405,696,650.00	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(405,696,650.00)	-
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	143,614,512.00	-
250006	Бусад зардал	143,614,512.00	-
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(143,614,512.00)	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	257,921,878.13	-	5,196,911,306.01	5,454,833,184.14
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	257,921,878.13	-	5,196,911,306.01	5,454,833,184.14
Тайлант үеийн үр дүн	-	-	(1,103,846,517.13)	(1,103,846,517.13)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	257,921,878.13	-	4,093,064,788.88	4,350,986,667.01
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	257,921,878.13	-	4,093,064,788.88	4,350,986,667.01
Тайлант үеийн үр дүн	-	-	(1,136,621,882.28)	(1,136,621,882.28)
2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	257,921,878.13	-	2,956,442,906.60	3,214,364,784.73

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,667,765,300.00	3,229,032,418.53	2,438,732,881.47	57.0
12	Татварын бус орлого	5,667,765,300.00	3,229,032,418.53	2,438,732,881.47	57.0
120	Нийтлэг татварын бус орлого	811,100,000.00	1,492,269,104.13	(681,169,104.13)	184
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	811,100,000.00	1,482,269,104.13	(671,169,104.13)	182.7
120009	Бусад орлого	-	10,000,000.00	(10,000,000.00)	-
122	Тусламжийн орлого	4,856,665,300.00	1,736,763,314.40	3,119,901,985.60	35.8
122005	Төсвөөс санхүүжих	4,856,665,300.00	1,736,763,314.40	3,119,901,985.60	35.8
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,667,765,300.00	3,229,032,418.53	2,438,732,881.47	57.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,667,765,300.00	3,229,032,418.53	2,438,732,881.47	57.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,587,566,100.00	3,148,833,312.70	2,438,732,787.30	56.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,361,136,800.00	1,344,551,385.63	16,585,414.37	98.8
210101	Үндсэн цалин	743,249,700.00	741,830,726.86	1,418,973.14	99.8
210102	Нэмэгдэл	224,813,200.00	223,121,531.00	1,691,669.00	99.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	265,888,600.00	265,888,600.00	-	100.0
210104	Урамшуулал	111,900,000.00	98,913,195.77	12,986,804.23	88.4
210105	Гэрээт ажлын хөлс	15,285,300.00	14,797,332.00	487,968.00	96.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	153,826,300.00	153,672,500.00	153,800.00	99.9
210201	Тэтгэврийн даатгал	104,601,600.00	104,497,300.00	104,300.00	99.9
210202	Тэтгэмжийн даатгал	12,306,200.00	12,294,000.00	12,200.00	99.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,153,100.00	6,146,800.00	6,300.00	99.9
210204	Ажилгүйдлийн даатгал	6,153,100.00	6,146,800.00	6,300.00	99.9
210205	Эрүүл мэндийн даатгал	24,612,300.00	24,587,600.00	24,700.00	99.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	68,026,300.00	42,818,916.07	25,207,383.93	62.9
210301	Гэрэл, цахилгаан	32,377,700.00	20,096,869.99	12,280,830.01	62.1
210302	Түлш, халаалт	10,922,500.00	8,384,777.61	2,537,722.39	76.8
210303	Цэвэр, бохир ус	9,876,100.00	5,427,268.47	4,448,831.53	55.0
210304	Байрны түрээс	14,850,000.00	8,910,000.00	5,940,000.00	60.0
2104	Хангамж, бараа материалын зардал	80,015,500.00	43,066,529.00	36,948,971.00	53.8
210401	Бичиг хэрэг	16,305,800.00	9,087,500.00	7,218,300.00	55.7
210402	Тээвэр, шатахуун	17,024,400.00	12,024,400.00	5,000,000.00	70.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	22,707,300.00	6,096,714.00	16,610,586.00	26.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,290,100.00	-	1,290,100.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22,687,900.00	15,857,915.00	6,829,985.00	69.9
2105	Нормативт зардал	135,365,000.00	104,975,158.00	30,389,842.00	77.5

Усны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	123,434,500.00	104,975,158.00	18,459,342.00	85.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,930,500.00	-	11,930,500.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	55,363,700.00	23,350,200.00	32,013,500.00	42.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	38,297,200.00	12,497,150.00	25,800,050.00	32.6
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,543,500.00	1,330,050.00	6,213,450.00	17.6
210604	Урсгал засвар	9,523,000.00	9,523,000.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	72,257,600.00	41,116,600.00	31,141,000.00	56.9
210702	Дотоод албан томилолт	72,257,600.00	41,116,600.00	31,141,000.00	56.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,642,298,300.00	1,376,005,424.00	2,266,292,876.00	37.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,565,287,400.00	1,338,125,951.00	2,227,161,449.00	37.5
210803	Даатгалын үйлчилгээ	1,620,000.00	1,612,632.00	7,368.00	99.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,783,000.00	2,553,161.00	229,839.00	91.7
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	558,000.00	558,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	52,798,100.00	21,969,400.00	30,828,700.00	41.6
210807	Газрын төлбөр	1,288,200.00	1,161,280.00	126,920.00	90.1
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	17,963,600.00	10,025,000.00	7,938,600.00	55.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,276,600.00	19,276,600.00	-	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,916,600.00	14,916,600.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,360,000.00	4,360,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	80,199,200.00	80,199,105.83	94.17	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	80,199,200.00	80,199,105.83	94.17	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	80,199,200	80,199,105.83	94.17	100.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	35	35	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	35	35	-	100.0
620001	Удирдах ажилтан	4	4	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	27	27	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	4	4	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	-	70,377,956.50
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	70,377,956.50
Тусламжийн орлого	-	70,377,956.50
Хандив тусламж / дотоод/	-	70,377,956.50
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	70,377,956.50
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	70,377,956.50
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	48,739,000.00
УРСГАЛ ЗАРДАЛ	-	48,739,000.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	43,739,000.00
Хангамж, бараа материалын зардал	-	7,029,000.00
Тээвэр, шатахуун	-	7,029,000.00
Томилолт, зочны зардал	-	7,710,000.00
Дотоод албан томилолт	-	7,710,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	-	29,000,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	-	29,000,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	5,000,000.00
Бусад урсгал шилжүүлэг	-	5,000,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	5,000,000.00
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	21,638,956.50
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(21,638,956.50)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Усны газар нь Улсын Их Хурлын 2020 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн “Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийг батлахдаа Усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхийг тусгаж өгснөөр Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн 121 дүгээр тогтоолоор байгуулагдсан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Үйл ажиллагааны чиглэл:

- Усны нөөцийн хомсдолоос сэргийлж, гадаргын усыг хуримтлуулан, эрэлт хэрэгцээг хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлэх;
- Усны нөөцийн шаталсан үнэ тарифын тогтолцоог бүрдүүлэн, цэвэр усны үнэлэмжийг нэмэгдүүлж хамгаалах;
- Усны нөөцийг хуримтлуулах, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулж, усны бохирдол, хомсдолыг бууруулах;
- Газрын байгалийн тогтоц, голын татамд хур тунадас, хайлсан цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм, далд усан сангууд байгуулж, томоохон голууд дээр урсцын тохируулгатай, олон зориулалтаар ашиглах усан сан барьж эхлэх;
- Хүн амыг баталгаат ундны усаар хангах, усны нөөцийн эрэл, хайгуул, зураглалын ажлыг эрчимжүүлж нөөц баялгийн мэдээллийн бааз суурийг өргөжүүлэх, төлөвлөлт, менежмент хийх нөхцөлийг бүрдүүлэх;
- Говийн ус хангамжийг нэмэгдүүлэх, усны мега төслийг хэрэгжүүлэх гэх мэт үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

Усны газар нь эрхэм зорилгоо “Монгол улсын хүн ам, улс орны эдийн засгийг баталгаатай, хүрэлцээтэй усаар найдвартай хангаж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эко системийн тэнцвэрт байдлыг тогтвортой хадгалахад чиглэгдсэн бодлогыг хэрэгжүүлж, байгалийн үнэт баялаг болох усны нөөцөө хамгаалах, хэмнэлттэй, зүй зохистой ашиглах хандлагыг улс орон даяар хэвшүүлэхэд оршино” гэж тодорхойлжээ.

Усны газар нь эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагааны стратегийн дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, дүрэм, журмын хэрэгжилтийг зохион байгуулах ажлын уялдаа холбоог хангах, төрийн захиргааны удирдлагын манлайлал, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, дотоод, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэн, иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүнд сурталгүй, хүртээмжтэй, ил тод, хялбар хүргэх;
- Усны нөөцийг судалж тогтоох, усны нөөц, түүний сав газрыг хамгаалах, нөхөн сэргээх, бохирдохоос урьдчилан сэргийлэх, усны сав газрын менежментийн тогтолцоог бэхжүүлэх;
- Усны нөөцийг зохистой ашиглах усны талаарх хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх ажлын зохион байгуулах, гадаргын усыг хуримтлуулан хэрэгцээг хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлэх, зохицуулах, мэргэжил арга зүйгээр хангах;
- Хаягдал усыг цэвэрлэж дахин ашиглах, эргүүлэн ашиглах бодлогыг дэмжих үр ашигтай хэрэглээг төлөвшүүлэх юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус газар нь үйл ажиллагаандаа Усны тухай хууль, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Гол, мөрний урсац бүрэлдэх, эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль, Ус бохирдуулсны

төлбөрийн тухай хууль, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа,ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиуд болон Засгийн газрын 2013 оны “Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай” 326 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 416 дугаар тогтоолыг тус тус мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжид өөрчлөлт ороогүй байна. Үйл ажиллагаа, бодлого чиглэлд орсон өөрчлөлт

- БОУАӨС-ын 2025 оны “Говийг усжуулах, судалгааны нэгж байгуулах тухай” А/676 дугаар тушаал;
- БОУАӨС-ын 2025 оны “Усны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр болон зохион байгуулалтын бүтцийг өөрчлөн батлах тухай” А/691 дүгээр тушаал;
- Сангийн сайдын 2025 оны “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам” шинэчлэн тухай А/03 дугаар тушаал.

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үнэллээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Усны газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус газар нь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2020 оны А/641 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Усны газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 358,361.6 мянган төгрөгөөр буюу 8.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	14,538.6	695,980.3	681,441.7
Урьдчилгаа	9,500.0	-	(9,500.0)
Бараа материал	63,704.0	513,438.5	449,734.5
Үндсэн хөрөнгө	4,263,244.0	3,499,929.4	(763,314.6)
Нийт хөрөнгө	4,350,986.6	4,709,348.2	358,361.6
Өр төлбөр	-	1,494,983.4	1,494,983.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,350,986.6	3,214,364.8	(1,136,621.8)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/ өмчийн дүн	4,350,986.6	4,709,348.2	358,361.6

Авлага дансны үлдэгдэл 681,441.7 мянган төгрөгөөр өссөн нь Сангийн сайдын 2025 оны 240 дүгээр тушаалын дагуу 671,169.1 мянган төгрөгийн давсан орлого, албан хаагчидтай холбоотой 3,172.2 мянган төгрөгийн авлага, татаас санхүүжилтийн 21,638.9 мянган төгрөгийн авлага тус тус бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 449,734.5 мянган төгрөгөөр өссөн нь Шинжлэх ухааны академийн Геоэкологийн хүрээлэнд хүлээлгэн өгөх “Эгийн голын усан цахилгаан станцын судалгаа”-ны ажилд шаардлагатай 465,000.0 мянган төгрөгийн багаж, тоног төхөөрөмжийг орлогод авсан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 763,314.6 мянган төгрөгөөр буурсан нь GIZ төслөөс 34,273.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж хүлээн авсан, 242,376.9 мянган төгрөгийн их засварын зардлыг капиталжуулсан, ТӨБЗГ-ын 2025 оны 432 дугаар тогтоолоор 516,813.8 мянган төгрөгийн тэг үлдэгдэлтэй хөрөнгийн үнийг 255,501.5 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон, харьяа сав газрын захиргаадугаар 212,648.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг шилжүүлсэн, 21,222.6 мянган төгрөгийн хөрөнгө акталсан, элэгдэл 1,118,671.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Өр төлбөр 1,494,983.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд хөтөлбөр арга хэмжээний хүрээнд гэрээ байгуулан, хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн санхүүжилтийг Монгол Улсын Ерөнхий Сайдын 2025 оны 05 дугаар албан даалгаврын хүрээнд олгоогүйтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо данс тайлант үеийн үр дүн 1,136,621.8 мянган төгрөгөөр буурсан.

Тус газрын биет бус хөрөнгө дансанд 1,343.8 мянган төгрөгийн Санхүүгийн тооцоолол ХХК-ийн Acoulus санхүүгийн программ, 275.0 мянган төгрөгийн нэмэлт хөгжүүлэлттэй, 1,267.9 мянган төгрөгийн Си ти эс ХХК-ийн санхүүгийн CTSsystem 6.0 UNITS нэгтгэлийн программ, 35,000.0 мянган төгрөгийн Инженер геодизи ХХК-ийн Голын голдирлын өөрчлөлт, морфодинамикийн загварын программ хангамжууд бүртгэлтэй. Засвар үйлчилгээний жилийн төлбөр 450.0 мянган төгрөг байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус газар 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 47,501,125.1 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 811,100.0 мянган төгрөг, нийт зарлагыг 48,312,225.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас хөтөлбөр, хөрөнгө оруулалтын зардлыг 34,551,292.5 мянган төгрөг, урсгал зардлыг 1,253,567.3 мянган төгрөгөөр бууруулж, 12,507,365.3 мянган

төгрөгөөр баталсан байна. Энэ нь хөтөлбөр, хөрөнгө оруулалтын төсвийн төсөлд багтсан хөв цөөрөм байгуулах төслүүдийн зураг төсөв хангалтгүй байгаагаас шалтгаалсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 263,608.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгож, 5,667,765.3 мянган төгрөгөөр батлагдснаас Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Усны нөөц, нуур, гол мөрний менежмент хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,856,665.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 811,100.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,445,648.9 мянган төгрөгийн санхүүжилт, бусад орлого 10,000.0 мянган төгрөг, үйл ажиллагааны орлого 1,482,269.1 мянган төгрөг, нийт 3,937,918.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, 3,229,032.4 мянган төгрөгийг зарцуулж, 708,885.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлснээс давсан орлого 671,169.1 мянган төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар тайлагнасан байна.

Тайлант онд өөрийн орлого 671,169.1 мянган төгрөгөөр давж биелсэн нь усны шинжилгээний тарифыг 10 дугаар сард өөрчилснөөс үнийн зөрүүгийн орлого 58,000.0 мянган төгрөг олсон мөн лабораторын тоног төхөөрөмжийг шинэчлэн олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн багаж тоног төхөөрөмжөөр хангаснаар шинжилгээний бүтээмж нэмэгдэж, үйлчилгээний чанар сайжирсан нь орлого өсөхөд нөлөөлсөн, орлогын өсөлтөөр төсвийн тодотголыг хийгээгүй, төсвийг үндэслэлтэй төлөвлөөгүй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,229,032.4 мянган төгрөг буюу 57.0 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 223,700.1 мянган төгрөгөөр, Усны нөөц, нуур, гол мөрний менежмент хөтөлбөрийн зардлын төсвийг 2,078,537.1 мянган төгрөгөөр, гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төсвийг 126,423.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан нь батлагдсан төсвийн зарцуулалтын эрхийг нээж өгөөгүйтэй холбоотой 1,494,983.3 мянган төгрөгийн өр тайлагнасан, 235,400.0 мянган төгрөгийн төсөвлөсөн ажил дутуу хийгдсэн мөн үйл ажиллагааны зардлын хэмнэлттэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71404	Усны нөөц, нуур, гол мөрний менежмент хөтөлбөр	5,667,765.3	3,229,032.4	2,438,732.9	57.0
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,962,480.9	1,738,780.8	223,700.1	88.6
80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	230,000.0	103,576.6	126,423.4	45.0
80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	3,382,177.5	1,303,640.4	2,078,537.1	38.5
80219	Харуул, хамгаалалтын зардал	12,907.7	2,835.5	10,072.2	22.0
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	80,199.2	80,199.1	0.1	100.0

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад тус байгууллагаас дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ. Тухайлбал

1. Усны газрын даргын 2025 оны А/145 дугаар тушаалаар төрийн албан хаагчдын 9 хувийн орон тооны цомхтголыг хэрэгжүүлж 38 орон тоог бууруулж 35 орон тоог баталж, мөрдсөн. Бүтцээр сул орон тооны 2 ажлын байр болон дотоод аудитын 1 ажлын байр тус тус хасагдсан байна.
2. Усны газрын даргын 2024 оны А/162 дугаар тушаалын дагуу нэг өдрийн хоол, унааны хөнгөлөлтийг 34.0 мянган төгрөгөөр тооцон олгож байна.

Албан хаагчийн нэг өдрийн хоол, унааны хөнгөлөлтөд нийт 265,888.6 мянган төгрөгийг төлөвлөж, гүйцэтгэлээр 265,888.6 мянган төгрөг зарцуулсан. Төсвийн хуваарийн 12 сард хийсэн өөрчлөлтөөр хэтэрсэн 109,370.0 мянган төгрөгийн зөрүүг арилгасан байна.

3. Хилийн усыг хамгаалах, ашиглах Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу БНХАУ болон ОХУ-д жил бүр зохион байгуулагддаг хуралдаанд оролцох гадаад томилолтын зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын ангиллаас 139,389.4 мянган төгрөгийг зарцуулсан байна. Хуралдаанаар Хэрлэн гол, Булган гол, Халх гол, Буйр нуурын усны нөөц, ус ашиглалт, усны барилга байгууламжтай холбоотой асуудал, мөн Байгал нуур, Сэлэнгэ мөрөнд “Эгийн гол” төсөлд үзүүлэх боломжит нөлөөллийн үнэлгээ хийх Монгол, Оросын хамтарсан ажлын төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх талаар хамтарсан шинжээчдийн хэсгийг байгуулсан байна.
4. Тайлант онд стандарт хэмжлийн сургалтад 360.0 мянган төгрөг, албан хаагчдын дунд сэтгэл зүйн сургалт, зөвлөгөө, оношилгоо сэдэвт сургалтад 4,000.0 мянган төгрөг, нийт 4,360.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.
5. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар "Цэнхэр алт 2" үндэсний чуулган зохион байгуулахад 370,000.0 мянган төгрөг төсөвлөснөөс 78,525.0 мянган төгрөгийг хэвлэл, мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулан ажилласан байна. Дээрх чуулганыг "Мөстөл мөсөн голоо хамгаалья" уриан дор шууд дамжуулалт болон цаг үеийн шинжтэй мэдээ мэдээлэл хүргэж, иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад усны нөөцийн нэгдсэн менежментийн тулгамдаж буй асуудал, жигд хуваарилалтын талаарх ойлголтуудыг түгээсэн.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 70,377.9 мянган төгрөгийг бүрдүүлж, хөрсний шинжилгээ, ажлын урамшуулал болон дотоод томилолт, түүнтэй холбоотой зардалд 48,739.0 мянган төгрөгийг зарцуулж, 21,638.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.3.1 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Усны нөөц, нуур, гол мөрний менежмент хөтөлбөрийн 11 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	“Эгийн голын усан цахилгаан станц” төслийн Сэлэнгэ мөрний сав газрын экосистемд үзүүлэх өөрчлөлтийг	2025 он	Усан цахилгаан станц байгуулах	Шинжлэх Ухааны Академтай 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан. Ажлын тайланг 2025 оны 11 сард ажлын хүлээлгэн өгсөн.	1,985,691.2	820,000.0

Усны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	тодорхойлох судалгааг хийх					
2	Дэлхийн ус намгархаг газар, Дэлхийн усны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээг зохион байгуулах, олон нийтэд мэдээлэл түгээх	2025 он	Хөв цөөрөм байгуулах	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар "Цэнхэр алт 2" үндэсний чуулган зохион байгуулан ажиллаж "Мөстөл мөсөн голоо хамгаалья" уриан дор Нэг сум Нэг нуур хөтөлбөрийг зарлан тунхагласан.	370,000.0	304,195.0
3	Усны нөөцийн зөвлөлийн хурал зохион байгуулах	2025 он	Усны нөөцийг нэмэгдү ү-лэх	Тайлант онд 3 удаа хуралдаж, Хилийн усны хэлэлцээр, Эгийн голын усан цахилгаан станц төслийн хүрээнд хийгдэх судалгааны ажлуудын ажлын даалгаварыг батласан мөн 7 сав газрын уур амьсгалын өөрчлөлт, эрсдэл, эмзэг байдалтай уялдуулах төлөвлөгөө болон усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг баталсан.	35,692.0	10,456.0
4	Усны нөөцийг бохирдож хомстохоос хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, олон улсын хамтын ажиллагаа, олон улсын гэрээ конвенц, хилийн усыг хамгаалах, ашиглах	2025 он		МУ, БНХАУ-ын ЗГ хороондын Хилийн усны хамтарсан комиссын 9 дүгээр хуралдааныг 3 дугаар сарын 12, 13-ны өдрүүдэд Бээжин хотод, МУ, ОХУ-ын ЗГ хоорондын хэлэлцээрийн дагуу хамтарсан ажлын хэсгийн хуралдааныг 9 дүгээр сарын 10, 11-ний өдрүүд Екатеринбург хотод тус тус зохион байгуулагдсан.	323,946.2	139,389.4
5	Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан боловсруулах	2025 он	Усны тухай хуулийг сайжруулах	БОУАӨЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр баталсан ажлын даалгаврын дагуу "Хүннү нэйчур" ХХК-тай 5 дугаар сарын 21-ний өдөр гэрээ байгуулж, 12 дугаар сарын 20-ны өдөр хүлээлгэн өгсөн.	19,800.0	9,900.0
6	Усны тухай хуулийг сурталчлах, нөлөөллийн ажлыг зохион байгуулах	2025 он		2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр тохиох "Дэлхийн жорлонгийн өдөр"-ийн хүрээнд "Усны тухай хууль" болон "Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль"-ийг олон нийтэд таниулан сурталчлах, байсан боловч төсвийн хэмнэлтийн дагуу хийгдээгүй.	17,400.0	-
7	Улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг	2025 он		Тус төлөвлөгөө нь 2013 оноос 2021 онд хэрэгжиж дууссантай холбоотой шинэчилсэн төлөвлөгөөг	18,050.0	-

Усны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	шинэчлэн боловсруулах			ЗГХЭГ-т хүргүүлсэн боловч "Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль"-д заасан хөгжлийн бодлогын баримт бичгийн төрөлд хамаарах асуудал тул буцаасан.		
8	Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн үр дагаврын үнэлгээ хийх, хуулийн төсөл боловсруулах хэлэлцүүлэг зохион байгуулах	2025 он		"Монголын гол нууруудын нэгдсэн хөдөлгөөн" ТББ-тай 2025 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн УГ/25 тоот гэрээний дагуу ажлын тайланг 5 дугаар сарын 26-ны өдөр хүлээлгэн өгсөн.	19,750.0	19,700.0
10	Булган аймгийн Баяннуурыг сэргээх ажил	2024 он-2025 он	Нуур сэргээх	Булган аймгийн Баяннуур сумын Баяннуурыг сэргээх ажлыг 2025 оны 11 сард дуусган Улсын комисст хүлээлгэн өгсөн.	123,603.3	-
11	Эрээн нуурыг сэргээх ажлыг үргэлжлүүлэх	2024 он-2025 он	Нуур сэргээх	"Эрээн нуурыг сэргээх төсөл"-ийн хүрээнд Завхан голын голдрил шилжүүлэх, ёроолын түвшин өргөх; Ус халиах далан; Завхан голын салааг хааж, Эрээн нуур руу чиглүүлэх далан; автозамын гарам буюу гарц;Явган хүний гүүр; Автомашин зогсоол; гүйцэтгэж, улсын комисст хүлээлгэн өгсөн.	200,000.0	-

Улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах, Усны тухай хуулийг сурталчлах, нөлөөллийн ажлыг зохион байгуулах ажлуудыг 2025 оны 10, 11 дүгээр саруудын хооронд хийхээр төлөвлөсөн боловч төсвийн хэмнэлтийн хүрээнд хийгдээгүй.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 4 удаа өөрчлөн баталсан байна. Үүнд:

1. БОУАӨС-ын 2025 оны А/08 дугаар, А/78 дугаар, А/131 дүгээр тус тус тушаалын дагуу төлөвлөгөөг 13,116,575.5 мянган төгрөгөөр буюу 660,090.0 мянган төгрөгөөр илүү;
2. БОУАӨС-ын 2025 оны А/275 дугаар тушаалын дагуу төлөвлөгөөг 3,801,201.2 мянган төгрөгөөр буюу 1 ажлыг 1,519,975.5 мянган төгрөгөөр дутуу, 1 ажлыг 400,000.0 мянган төгрөгөөр илүү;
3. БОУАӨС-ын 2025 оны А/656 дугаар, А/673 дугаар тус тус тушаалын дагуу төлөвлөгөөг 3,753,177.5 мянган төгрөгөөр дутуу;
4. БОУАӨС-ын 2025 оны А/903 дугаар дагуу 3,281,168.7 мянган төгрөг.

Төлөвлөгөөг өөрчлөх тухай бүрд бараа, ажил, үйлчилгээний дүн өөрчлөгдөж, хасагдаж, нэмэгдэж байгаа нь төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөөгүйтэй холбоотой байна.

Гүйцэтгэлээр нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 2 харилцагчтай 1,588,045.0 мянган төгрөгийн гэрээ, шууд худалдан авалтын аргаар 1 харилцагчтай 1,519,975.4 мянган төгрөгийн гэрээ тус тус байгуулж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Усны газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, төсвийн орлогын бүрдүүлэлтэд хяналт тавих, ажил гүйлгээг анхан шатны баримтаар баталгаажуулах, баримтын бүрдлийг хангуулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Мишээл-Од Аудит” ХХК-ийн ахлах аудитор М.Цэнд-Аюуш, аудитор Д.Дэлгэрмаа нар гүйцэтгэж, захирал Т.Одончимэг, чанарын хяналтын менежер Э.Энхцэцэг нар анхан шатны хяналтыг, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор О.Баярмаа, аудитын менежер Э.Энхбаатар, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг хэрэгжүүлсэн.

Усны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 01/35 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нийт зардлын 10,239,515.3 мянган төгрөгөөс 1 хувиар тооцож 102,395.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянах шаардлагатай гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой байгууллага өмнөх оноос байр ашиглалттай холбоотой зардлыг 25,207.4 мянган төгрөг, шуудан холбооны зардлыг 16,610.6 мянган төгрөг, нормын хувцасны зардлыг 11,930.5 мянган төгрөг, тээвэр шатахууны зардлыг 15,000.0 мянган төгрөг, нийт 68,748.5 мянган төгрөгөөр төсвийг дутуу зарцуулж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 12,422,672.9 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 4 албан шаардлага хүргүүлжээ.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хугацаанд нь иж бүрэн байршуулах гэсэн зөвлөмж хэрэгжээгүй тайлант онд Шилэн дансны цахим хуудсанд 4 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мөн Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий

18,713.8 мянган төгрөгийн орлогын 1 гүйлгээг мэдээлээгүй, 1,132,617.8 мянган төгрөгийн орлогын 16 гүйлгээ, 40 удаагийн 585,523.4 мянган төгрөгийн зарлагын 40 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралт "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2.10-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд иж бүрэн, үнэн зөв байршуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлахдаа Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/08 дугаар тушаалаар баталсан хөрөнгө оруулалтын 3 төсөл арга хэмжээг 660,090.0 мянган төгрөгөөр илүү тусгасан. Тайлант онд төлөвлөгөөнд 4 удаа өөрчлөлт оруулсан бөгөөд сүүлийн 2 төлөвлөгөөг батлахдаа 2025 оны 5 дугаар сарын 23-ны өдөр 1,125,000.0 мянган төгрөгөөр цахимд зарлаж, 1,123,000.0 мянган төгрөгөөр гэрээ байгуулсан 1 ажлыг 1,099,200.0 мянган төгрөг буюу 25,800.0 мянган төгрөгөөр бууруулан баталсан. Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авахаар төлөвлөсөн 693,946.2 мянган төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ, харьцуулалтын аргаар худалдан авахаар төлөвлөсөн 35,692.0 мянган төгрөгийн 1 төсөл, арга хэмжээг тус тус шууд худалдан авалт хийсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно", 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

2. Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар сонгон шалгаруулсан 1 төсөл арга хэмжээний 1,123,045.0 мянган төгрөгийн гэрээг байгуулахдаа 33,750.0 мянган төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг байршуулаагүй байхад гэрээг байгуулсан буюу гэрээ байгуулснаас 9 хоногийн дараа гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааг байршуулсан байна. Мөн 1 төсөл арга хэмжээний 465,000.0 мянган төгрөгийн гэрээг байгуулахдаа 13,950.0 мянган төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг гаргуулан аваагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6-д "Дараах нөхцөлийн аль нэг үүссэн бол захиалагч тендерийн баталгааг улсын орлого болгоно", 14.6.2-т "гэрээ байгуулах эрх авсан оролцогч тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу гэрээ байгуулах, эсхүл гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх үүргээ хэрэгжүүлээгүй", 42 дугаар зүйлийн 42.1-д "Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана.", 42.2-т "Захиалагч гүйцэтгэлийн баталгааны дүнг тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувиар тогтоож тендер шалгаруулалтын баримт бичигт тусгана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гүйцэтгэлийн баталгааг гаргуулан аваагүй гэрээ байгуулдаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

3. Усны нөөцөд учруулсан хохирлын нөхөн төлбөрт 44 харилцагчид 9,266,742.0 мянган төгрөгийн төлбөр ногдуулснаас 8,656,518.4 мянган төгрөгийн төлбөр төлөгдөөгүй, Усны нөөц ашигласны төлбөрийг 308 байгууллагад 119,814,399.2 мянган төгрөгийн ногдуулалт хийснээс 22,708,175.5 мянган төгрөг дутуу төвлөрсөн, 7 байгууллагын 238,550.4 мянган төгрөгийн төлбөр төлөгдөөгүй, 43 байгууллагатай гэрээ дүгнэхгүйгээр дараа оны тооцоолол хийж ногдуулалт гаргасан нь холбогдох журмыг зөрчсөн, Ус бохирдуулсны төлбөрт 252 дүгнэлтээр 11,121,090.2 мянган төгрөгийн төлбөр тооцоолж, 9,124,633.2 мянган төгрөгийг чөлөөлж, 105 харилцагчийн 327,520.9 мянган төгрөгийн төлбөр төлөгдөөгүй байгаа зэрэг нь төлбөрийн биелэлтэд тавих хяналт хангалтгүй байна.

Энэ нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 1-т “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчин болон байгалийн нөөцөд хохирол учруулсан бол нөхөн төлбөр төлөх бөгөөд нөхөн төлбөрийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан Байгаль орчин, уур амьсгалын санд оруулна”, 8-д “Нөхөн төлбөрийг ногдуулсан байгаль орчны хяналтын улсын байцаагч ажлын 14 хоногт багтаан тухайн төлбөрийг барагдуулах үүрэгтэй бөгөөд уг хугацаанд барагдуулаагүй тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангуулна”, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-т “Сум, дүүргийн Засаг дарга, орон нутгийн зэрэглэлтэй хотын Захирагчийн томилсон албан тушаалтан байгалийн нөөцийг ашиглах зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын талаарх мэдээллийг зөвшөөрөл олгосон өдрөөс хойш 10 хоногийн дотор зохих шатны татварын албанд гаргаж өгөх бөгөөд татварын алба уг мэдээллийг үндэслэн төлбөр төлөгчийг бүртгэнэ”, Усны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-т “Усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны алба, хөдөө аж ахуйн мэргэжилтэн болон сум дүүргийн байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчийг усны талаарх мэргэжил, арга зүйн удирдлагар хангана”, 16.4.9-д “энэ хуулийн 28.4-т заасны дагуу гаргасан ус ашиглах дүгнэлт, 28.6-д заасан ус ашиглах зөвшөөрөл, 28.11-д заасан гэрээнд хяналт тавих”, 25 дугаар зүйлийн 25.2-т “Ус бохирдуулагч нь бохирдуулах бодисыг хаягдал усны стандартад заасан хэмжээнээс хэтрүүлэн гаргасан тохиолдолд байгаль орчны итгэмжлэгдсэн лабораторын шинжилгээний дүгнэлтийг үндэслэн байгаль орчны байцаагч ус бохирдуулсны нөхөн төлбөрийг ногдуулж, төлөлтөд хяналт тавих бөгөөд нөхөн төлбөрийн хэмжээг ус бохирдуулсны төлбөрийг хоёроос тав дахин шатлан өсгөх хэлбэрээр нэмэгдүүлж, бохирдуулах бодис бүрээр тогтооно”, 25.4-т “Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг холбогдох иргэн, аж ахуйн нэгж байгууллага Байгаль орчин, уур амьсгалын санд төлнө” Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т “Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төлбөрийн нэгдсэн тайланг дараа оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор гаргаж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн биелэлтэд хяналт тавьж, орлогыг бүрэн төвлөрүүлэх ажлыг зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 улирлын санхүүгийн тайланг хамруулж, өмнөх оны зөвлөмжийн биелэлт, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, цалин хөлс, татварын бүртгэл, өглөг, авлагын дансны хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлсэн алдаа, зөрчлийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан. Завсрын аудитаар нийт 18,501,011.6 мянган төгрөгийн 14 алдаа илрүүлснийг аудитын явцад залруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 4,538.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 446,798.0 мянган төгрөгийн 4 зөрчлийг арилгах албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 14,646.9 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгснөөс тайлант онд 1 төлбөрийн акт, 4 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	4,538.6	1	4,538.6	100.0
Албан шаардлага	4	446,798.0	4	446,798.0	100.0
Зөвлөмж	1	14,646.9	-	-	-
Нийт дүн	6	465,983.5	5	451,336.6	83.3

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хугацаанд нь иж бүрэн байршуулах гэсэн зөвлөмж хэрэгжээгүй тайлант онд Шилэн дансны цахим хуудсанд 4 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мөн Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 18,713.8 мянган төгрөгийн орлогын 1 гүйлгээг мэдээлээгүй, 1,132,617.8 мянган төгрөгийн орлогын 16 гүйлгээ, 40 удаагийн 585,523.4 мянган төгрөгийн зарлагын 40 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилд албан шаардлага хүргүүлхээр шийдвэрлэсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг сайжруулахтай холбоотой дараах саналуудыг хүргүүлж байна. Үүнд:

1. Журмын хоёрдугаар хавсралтаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт болон Сангийн яамны finperform.mof.gov.mn сайт дахь маягт хоорондын зөрүүг арилгах.
2. Журмын гуравдугаар хавсралтаар батлагдсан дансны жишиг жагсаалтыг дээрх Сангийн яамны шинэ сайттай уялдуулах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 425,407.1 мянган төгрөгийн 7 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

- 19 албан хаагчдад илүү олгосон хоол унааны 2,958.0 мянган төгрөг, 1 албан хаагчид ээлжийн амралтын хоног болон ажилласан хоногийг давхардуулан олгосон 214.2 мянган төгрөгийн цалинг авлагаар бүртгээгүй нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартын 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой” гэсэн заалт, санхүүгийн тайлагналын “толилуулга” батламж мэдэгдлийг хангаагүй;
- Нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн, Сангийн яамнаас буцаан авах 21,638.9 мянган төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгээгүй нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартын 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой” гэсэн заалт, санхүүгийн тайлагналын “толилуулга” батламж мэдэгдлийг хангаагүй;
- Бараа материалын дансанд бүртгэх Шинжлэх ухааны академын Газарзүй геоэкологийн хүрээлэнд хүлээлгэн өгөх 380,045.0 мянган төгрөгийн багаж хэрэгслийг үндсэн хөрөнгөнд бүртгэж 9,658.9 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулсан нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартын 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой” гэсэн заалт, санхүүгийн тайлагналын “толилуулга” батламж мэдэгдлийг хангаагүй;
- Конторын барилгад сантехникийн их засвар орж 242,376.8 мянган төгрөгөөр капиталжуулсаны 176.4 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг алдаатай тайлагнасан нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартын 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой” гэсэн заалт, санхүүгийн тайлагналын “толилуулга” батламж мэдэгдлийг хангаагүй;
- 2025 оны санхүүгийн тайлангийн аудитын төлбөр 10,000.0 мянган төгрөгийн өглөгийг үүсгэн бүртгээгүй нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартын 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой” гэсэн заалт, санхүүгийн тайлагналын “толилуулга” батламж мэдэгдлийг хангаагүй;
- Газар зүй геоэкологийн хүрээлэнгийн багаж хэрэгсэл худалдан авах төсвөөс хэмнэгдсэн, буцаан төвлөрүүлэх ёстой 715.7 мянган төгрөгийг байгууллагад өгөх өглөгөөр тайлагнасан зэрэг алдаа нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартын 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой” гэсэн заалт, санхүүгийн тайлагналын “толилуулга” батламж мэдэгдлийг хангаагүй;

Аудитаар нийт 835,689.2 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд 3,179.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 192,740.5 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 639,769.3 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 835,689.2 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 779,017.5 мянган төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Томилолтын зардалд хяналт хэрэгжүүлэхэд 1 жолоочийг 2 өөр аймагт, ижил хугацаанд ажилласнаар баримтыг бүрдүүлж томилолтын олговрыг 2,715,.0 мянган төгрөг, мөн 2 албан хаагчид буудлын төлбөрийг 464.4 мянган төгрөг, нийт 3,179.4 мянган төгрөгийг илүү тооцож олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "үр ашигтай байх", 4.1.9-д "хариуцлагатай байх", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.10-т "Унааны зардлын баримт (онгоц, галт тэрэг, хот хоорондын нийтийн тээврийн тасалбар, автомашин хөлсөлсөн бол ажил гүйцэтгэх гэрээ эсхүл шатахуун худалдан авсан тасалбар)-ыг төрийн албан хаагч албан томилолтын тайландаа хавсаргах ба хоолны болон байрны зардлын баримтыг албан томилолтоор ажилласан төрийн албан хаагчаас шаардахгүй байж болно" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон томилолтын олговрыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Тайлант онд 129 харилцагчид үйлчилгээ үзүүлсний орлогын төлбөрийн баримтыг 50,416.9 мянган төгрөгөөр дутуу, 112 харилцагчид 125,899.7 мянган төгрөгийн төлбөрийн баримтыг илүү шивж олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2-д "хэрэглэгчийн системийн дамжуулсан мэдээллийг үндсэн системийн санд бүрэн, үнэн зөв нэгтгэх, эрх бүхий этгээдэд тайлагнах", 17.3.1-т "албан татвар төлөгчийн хийсэн төлбөр тооцооны мэдээллийг хэрэглэгчийн системд төлбөр хийсэн тухай бүр бүртгэнэ", 17.3.2-т "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно", 17.5-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримт олгохоос татгалзах, хуурамч буюу хийгдсэн төлбөр тооцооноос өөр дүнтэй төлбөрийн баримт олгохыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн баримтыг илүү, дутуу шивж олгодог зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант онд Итали улсад "Усны үнэ цэнэ" гэсэн хуралд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 2 албан хаагчид 16,423.9 мянган төгрөгийн зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-д "хариуцлагатай байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг таслан зогсоох.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээг цахим төлбөрийн баримттай тулган шалгахад 5 харилцагчийн 12,655.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авалтыг анхан шатны баримтаар баримтжуулж ажиллах.

2. Цалин хөлстэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/71 тоот тушаалыг үндэслэн 2025 оны 2 дугаар сараас 13 албан хаагчийн зэрэг дэвийн нэмэгдэл олгох хувь, хэмжээг нэмэгдүүлэн нийт 3,162.2 мянган төгрөгийг олгохдоо байгууллагын даргын тушаал шийдвэрийг тухайн хугацаанд гаргаагүй, 12 дугаар сард нөхөн гаргасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын 2.3-т заасан “Төрийн захиргааны ахлах түшмэл, дэс түшмэл, туслах түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох асуудлыг Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын Агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус шийдвэрлэнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалин урамшуулал олгохтой холбоотой тушаал шийдвэрийг тухайн цаг хугацаанд нь гаргаж, шийдвэрийг үндэслэж ажиллах

Илрүүлэлт: Тайлант онд 42 хүнд 32,600.0 мянган төгрөгийн ажлын хөлс олгохдоо 6,166.0 мянган нийгмийн даатгалын шимтгэлийг суутгаагүй олгосон байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4-д “үндсэн ажлаас бусад хуулийн этгээд, хүнээс олгосон энэ хуулийн 19.1.1-д заасан цалин хөлс, олговор” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хуульд заасны дагуу ажлын хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэл, татварыг суутгаж олгох

Илрүүлэлт: Тайлант онд бүтцийн өөрчлөлтөөр ажлаас чөлөөлөгдсөн 1 ажилтны 3 сарын цалинтай тэнцэх 1 удаагийн тэтгэмжийн зардал болох 4,617.0 мянган төгрөгийг олгоогүй, санхүүгийн тайланд өглөгөөр бүртгээгүй байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1.1-т “аж ахуйн нэгж, байгууллага, түүний салбар, нэгж татан буугдсан, ажлын байр хасагдсан, орон тоо цөөрсөн”, 82.1-т “Энэ хуулийн 65.4.2, 80.1.1, 80.1.2, 80.1.3-т заасан үндэслэлээр хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсан ажилтанд нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй эсэхээс үл хамааран ажил олгогч дараах хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Гаргасан тушаал, шийдвэрийн дагуу ажлаас халагдсан ажилтанд тэтгэмжийг олгох.

3. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг үндэслэлтэй төлөвлөгөөгүй, тодотголоор нэмэгдүүлээгүйгээс үйл ажиллагааны орлого 82.7 хувь буюу мянган төгрөгөөр давж 671,169.1 биелсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6-д “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнах үе шат бүрд төсвийн ангиллыг дараах байдлаар хэрэглэнэ”, 22.6.3-т “төсвийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналтыг төсвийн ангиллын төрөл тус бүрээр, тэдгээрийн дэлгэрэнгүй ангиллын дагуу бэлтгэх”, 22.6.4-т “төсөв батлах эрх бүхий байгууллага нь төсвийг шатлал бүрээр, түүнд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, тусгай сан, орлого, санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр нь батлах” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 12 дугаар сарын 30-ны 240 дугаартай тушаалын 3.3-т заасны дагуу төсвийг бодит тооцоололтой, үндэслэлтэйгээр төлөвлөж, гүйцэтгэлийг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Төсвийн төслийн тооцооллыг хийхдээ шаардлагатай

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	19 албан хаагчдад илүү олгосон хоол унааны 2,958.0 мянган төгрөг, 1 албан хаагчид ээлжийн амралтын хоног болон ажилласан хоногийг давхардуулан олгосон 214.2 мянган төгрөгийн цалинг авлагаар бүртгээгүй	1	3,172.2	1	3,172.2			1	3,172.2				
2	Нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн, Сангийн яамнаас буцаан авах 21,638.9 мянган төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгээгүй	1	21,638.9	1	21,638.9			1	21,638.9				
3	Бараа материалын дансанд бүртгэх Шинжлэх ухааны академын Газарзүй геоэкологийн хүрээлэнд хүлээлгэн өгөх 380,045.0 мянган төгрөгийн багаж хэрэгслийг үндсэн хөрөнгөнд бүртгэсэн	1	380,045.0			1	380,045.0	1	380,045.0				
4	Шинжлэх ухааны академын Газарзүй геоэкологийн хүрээлэнд хүлээлгэн өгөх 380,045.0 мянган төгрөгийн багаж хэрэгслийг үндсэн хөрөнгөнд бүртгэж 9,658.9 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулсан	1	9,658.9			1	9,658.9	1	9,658.9				
5	Конторын барилгад сантехникийн их засвар орж 242,376.8 мянган төгрөгөөр капиталжуулсаны 176.4 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг алдаатай тайлагнасан	1	176.4			1	176.4	1	176.4				
6	2025 оны санхүүгийн тайлангийн аудитын төлбөр 10,000.0 мянган төгрөгийг өглөг үүсгэн бүртгээгүй	1	10,000.0	1	10,000.0			1	10,000.0				
7	Газар зүй геоэкологийн хүрээлэнгийн багаж хэрэгсэл худалдан авах төсвөөс хэмнэгдсэн, буцаан төвлөрүүлэх ёстой 715.7 мянган төгрөгийг байгууллагад өгөх өглөгөөр тайлагнасан	1	715.7			1	715.7	1	715.7				
	Дүн	7	425,407.1	3	34,811.1	4	390,596.0	7	425,407.1	0	0.0	0	0.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Томилолтын зардалд хяналт хэрэгжүүлэхэд 1 жолоочийг 2 өөр аймагт, ижил хугацаанд ажилласнаар баримтыг бүрдүүлж томилолтын олговрыг 2,715.0 мянган төгрөг, мөн 2 албан хаагчид буудлын төлбөрийг 464.4 мянган төгрөг, нийт 3,179.4 мянган төгрөгийг илүү тооцож олгосон.	1	3,179.4	1	3,179.4								
2	Тайлант онд 129 харилцагчид үйлчилгээ үзүүлсний орлогын төлбөрийн баримтыг 50,416.9 мянган төгрөгөөр дутуу, 112 харилцагчид 125,899.7 мянган төгрөгийн төлбөрийн баримтыг илүү шивж олгосон байна.	1	176,316.6			1	176,316.6						
3	Тайлант онд Итали улсад "Усны үнэ цэнэ" гэсэн хуралд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 2 албан хаагчид 16,423.9 мянган төгрөгийн зардал гаргасан байна.	1	16,423.9			1	16,423.9						
4	Мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээг цахим төлбөрийн баримттай тулган шалгахад 5 харилцагчийн 12,655.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй байна.	1	12,655.0					1	12,655.0				
5	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/71 тоот тушаалыг үндэслэн 2025 оны 2 дугаар сараас 13 албан хаагчийн зэрэг дэвийн нэмэгдэл олгох хувь, хэмжээг нэмэгдүүлэн нийт 3,162.2 мянган төгрөгийг олгохдоо байгууллагын даргын тушаал шийдвэрийг тухайн хугацаанд гаргаагүй, 12 дугаар сард нөхөн гаргасан.	1	3,162.2					1	3,162.2				
6	Тайлант онд 42 хүнд 32,600.0 мянган төгрөгийн ажлын хөлс олгохдоо 6,166.0 мянган нийгмийн даатгалын шимтгэлийг суутгаагүй олгосон байна.	1	6,166.0					1	6,166.0				
7	Тайлант онд бүтцийн өөрчлөлтөөр ажлаас чөлөөлөгдсөн 1 ажилтны 3 сарын цалинтай тэнцэх 1 удаагийн тэтгэмжийн зардал болох 4,617.0 мянган төгрөгийг олгоогүй, санхүүгийн тайланд өглөгөөр бүртгээгүй байна.	1	4,617.0					1	4,617.0				

Усны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

8	Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг үндэслэлтэй төлөвлөгөөгүй, тодотголоор нэмэгдүүлээгүйгээс үйл ажиллагааны орлого 82.7 хувь буюу 671,169.1 мянган төгрөгөөр давж биелсэн.	1	613,169.1					1	613,169.1		
Дүн		8	835,689.2	1	3,179.4	2	192,740.5	5	639,769.3	0	0.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
				Албан шаардлага		Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
1	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хугацаанд нь иж бүрэн байршуулах гэсэн зөвлөмж хэрэгжээгүй тайлант онд Шилэн дансны цахим хуудсанд 4 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мөн Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 18,713.8 мянган төгрөгийн орлогын 1 гүйлгээг мэдээлээгүй, 1,132,617.8 мянган төгрөгийн орлогын 16 гүйлгээ, 40 удаагийн 585,523.4 мянган төгрөгийн зарлагын 40 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	1,736,855.0	1	1,736,855.0						
Дүн		1	1,736,855.0	1	1,736,855.0	0	0.0	0	0.0	0	0.0
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
1	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлахдаа Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/08 дугаар тушаалаар баталсан хөрөнгө оруулалтын 3 төсөл арга хэмжээг 660,090.0 мянган төгрөгөөр илүү тусгасан. Тайлант онд төлөвлөгөөнд 4 удаа өөрчлөлт оруулсан бөгөөд сүүлийн 2 төлөвлөгөөг батлахдаа 2025 оны 5 дугаар сарын 23-ны өдөр 1,125,000.0 мянган төгрөгөөр цахимд зарлаж, 1,123,000.0 мянган төгрөгөөр гэрээ байгуулсан 1 ажлыг 1,099,200.0 мянган төгрөг буюу 25,800.0 мянган төгрөгөөр бууруулан баталсан. Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авахаар төлөвлөсөн 693,946.2 мянган төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ, харьцуулалтын аргаар худалдан авахаар төлөвлөсөн 35,692.0 мянган төгрөгийн 1 төсөл, арга хэмжээг тус тус шууд худалдан авалт хийсэн.	1	1,415,528.2	1	1,415,528.2						

Усны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2	Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар сонгон шалгаруулсан 1 төсөл арга хэмжээний 1,123,045.0 мянган төгрөгийн гэрээг байгуулахдаа 33,750.0 мянган төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг байршуулаагүй байхад гэрээг байгуулсан буюу гэрээ байгуулснаас 9 хоногийн дараа гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааг байршуулсан байна. Мөн 1 төсөл арга хэмжээний 465,000.0 мянган төгрөгийн гэрээг байгуулахдаа 13,950.0 мянган төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг гаргуулан аваагүй байна.	1	47,700.0	1	47,700.0				
3	Усны нөөцөд учруулсан хохирлын нөхөн төлбөрт 44 харилцагчид 9,266,742.0 мянган төгрөгийн төлбөр ногдуулснаас 8,656,518.4 мянган төгрөгийн төлбөр төлөгдөөгүй, Усны нөөц ашигласны төлбөрийг 308 байгууллагад 119,814,399.2 мянган төгрөгийн ногдуулалт хийснээс 22,708,175.5 мянган төгрөг дутуу төвлөрсөн, 7 байгууллагын 238,550.4 мянган төгрөгийн төлбөр төлөгдөөгүй, 43 байгууллагатай гэрээ дүгнэхгүйгээр дараа оны тооцоолол хийж ногдуулалт гаргасан нь холбогдох журмыг зөрчсөн, Ус бохирдуулсны төлбөрт 252 дүгнэлтээр 11,121,090.2 мянган төгрөгийн төлбөр тооцоолж, 9,124,633.2 мянган төгрөгийг чөлөөлж, 105 харилцагчийн 327,520.9 мянган төгрөгийн төлбөр төлөгдөөгүй байгаа зэрэг нь төлбөрийн биелэлтэд тавих хяналт хангалтгүй байна.	1	9,222,589.7	1	9,222,589.7				
	Дүн	3	10,685,817.9	3	10,685,817.9	0	0.0	0	0.0
	Нийт дүн	4	12,422,672.9	4	12,422,672.9	0	0.0	0	0.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 68/A0150079

Улаанбаатар хот

САГ - 2026/244/НА - СГА - ТИЛЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Усны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Томилолтын зардалд хяналт хэрэгжүүлэхэд 1 жолоочийг 2 өөр аймагт, ижил хугацаанд ажилласнаар баримтыг бүрдүүлж томилолтын олговрыг 2,715,000.00 /хоёр сая долоон зуун арван таван мянган/ төгрөг, мөн 2 албан хаагчид буудлын төлбөрийг 464,400.00 /дөрвөн зуун жаран дөрвөн мянга дөрвөн зуун/ төгрөг, нийт 3,179,400.00 /гурван сая нэг зуун далан есөн мянга дөрвөн зуун/ төгрөгийг илүү тооцож олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах,", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "үр ашигтай байх", 4.1.9-д "хариуцлагатай байх", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.10-т "Унааны зардлын баримт (онгоц, галт тэрэг, хот хоорондын нийтийн тээврийн тасалбар, автомашин хөлсөлсөн бол ажил гүйцэтгэх гэрээ эсхүл шатахуун худалдан авсан тасалбар)-ыг төрийн албан хаагч албан томилолтын тайландаа хавсаргах ба хоолны болон байрны зардлын баримтыг албан томилолтоор ажилласан төрийн албан хаагчаас шаардахгүй байж болно" гэж заасантай нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Илүү олгосон 3,179,400.00 /гурван сая нэг зуун далан есөн мянга дөрвөн зуун/ төгрөгийг Усны газрын ахлах нягтлан бодогч /Д.Алтантуяа/ нөхөн төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Усны газрын дарга /З.Батбаяр/-т хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Т.ОДОНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 338/А0150079

Улаанбаатар хот

САГ-2026/244/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Усны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Усны нөөцөд учруулсан хохирлын нөхөн төлбөрт 44 харилцагчид 9,266,742,000.00 /есөн тэрбум хоёр зуун жаран зургаан сая долоон зуун дөчин хоёр мянган/ төгрөгийн төлбөр ногдуулснаас 560,324,200.00 /таван зуун жаран сая гурван зуун хорин дөрвөн мянга хоёр зуун/ төгрөгийг төвлөрүүлж, 8,656,518,400.00 /найман тэрбум зургаан зуун тавин зургаан сая таван зуун арван найман мянга дөрвөн зуун/ төгрөгийн төлбөр төлөгдөөгүй;
- Усны нөөц ашигласны төлбөрийг 308 байгууллагад 119,814,399,200.00 /нэг зуун арван есөн тэрбум найман зуун арван дөрвөн сая гурван зуун ерэн есөн мянга хоёр зуун/ төгрөгийн төлбөр ногдуулснаас 22,708,175,500.00 /хорин хоёр тэрбум долоон зуун найман сая нэг зуун далан таван мянга таван зуун/ төгрөг дутуу төвлөрсөн,
- 7 байгууллагын 238,550,400.00 /хоёр зуун гучин найман сая таван зуун тавин мянга дөрвөн зуун/ төгрөгийн төлбөр төлөгдөөгүй байхад 43 байгууллагатай гэрээ дүгнэхгүйгээр дараа оны тооцоолол хийж ногдуулалт гаргасан нь холбогдох журмыг зөрчсөн
- Ус бохирдуулсны төлбөрт 252 дүгнэлт гаргаж, 11,121,090,200.00 /арван нэгэн тэрбум нэг зуун хорин нэгэн сая ерэн мянга хоёр зуун/ төгрөгийн төлбөр тооцоолсноос 8,434,873,200.00 /найман тэрбум дөрвөн зуун гучин дөрвөн сая найман зуун далан гурван мянга хоёр зуун/ төгрөгийг чөлөөлж, 689,760,000.00 /зургаан зуун наян есөн сая долоон зуун жаран мянган/ төгрөгийг хөнгөлж, 2,199,652,900.00 /хоёр тэрбум нэг зуун ерэн есөн сая зургаан зуун тавин хоёр мянга есөн зуун/ төгрөг төлүүлэхээр ногдуулсан боловч 105 байгууллагын 327,520,900.00 /гурван зуун хорин долоон сая таван зуун хорин мянга есөн зуун/ төгрөгийн төлбөр төлөгдөөгүй зэрэг нь төлбөрийн биелэлтэд тавих хяналт хангалтгүй байна.

Энэ нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 1-т "Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчин болон байгалийн нөөцөд хохирол учруулсан бол нөхөн төлбөр төлөх бөгөөд нөхөн төлбөрийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан Байгаль орчин, уур амьсгалын санд оруулна", 8-д "Нөхөн төлбөрийг ногдуулсан байгаль орчны хяналтын улсын байцаагч ажлын 14 хоногт багтаан тухайн төлбөрийг барагдуулах үүрэгтэй бөгөөд уг хугацаанд барагдуулаагүй тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангуулна", Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-т "Сум, дүүргийн Засаг дарга, орон нутгийн зэрэглэлтэй хотын Захирагчийн томилсон албан тушаалтан байгалийн нөөцийг ашиглах зөвшөөрөл бүхий

иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын талаарх мэдээллийг зөвшөөрөл олгосон өдрөөс хойш 10 хоногийн дотор зохих шатны татварын албанд гаргаж өгөх бөгөөд татварын алба уг мэдээллийг үндэслэн төлбөр төлөгчийг бүртгэнэ", Усны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-т "Усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны алба, хөдөө аж ахуйн мэргэжилтэн болон сум дүүргийн байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчийг усны талаарх мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана", 16.4.9-д "энэ хуулийн 28.4-т заасны дагуу гаргасан ус ашиглах дүгнэлт, 28.6-д заасан ус ашиглах зөвшөөрөл, 28.11-д заасан гэрээнд хяналт тавих", 25 дугаар зүйлийн 25.2-т "Ус бохирдуулагч нь бохирдуулах бодисыг хаягдал усны стандартад заасан хэмжээнээс хэтрүүлэн гаргасан тохиолдолд байгаль орчны итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтийг үндэслэн байгаль орчны байцаагч ус бохирдуулсны нөхөн төлбөрийг ногдуулж, төлөлтөд хяналт тавих бөгөөд нөхөн төлбөрийн хэмжээг ус бохирдуулсны төлбөрийг хоёроос тав дахин шатлан өсгөх хэлбэрээр нэмэгдүүлж, бохирдуулах бодис бүрээр тогтооно", 25.4-т "Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг холбогдох иргэн, аж ахуйн нэгж байгууллага Байгаль орчин, уур амьсгалын санд төлнө" Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т "Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төлбөрийн нэгдсэн тайланг дараа оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор гаргаж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төлбөрийн биелэлтэд хяналт тавьж, орлогыг бүрэн төвлөрүүлэх ажлыг зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Усны газрын дарга /З.Батбаяр/, ахлах нягтлан бодогч /Д.Алтантуяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Т.ОДОНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 339/А0150079

Улаанбаатар хот

САГ-2026/244/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Усны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хугацаанд нь иж бүрэн байршуулах гэсэн зөвлөмж хэрэгжээгүй тайлант онд Шилэн дансны цахим хуудсанд 4 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мөн "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий мөнгөн гүйлгээ"-ээс 18,713,856.00 /арван найман сая долоон зуун арван гурван мянга найман зуун тавин зургаан/ төгрөгийн орлогын 1 гүйлгээг мэдээлээгүй, 1,132,617,790.00 /нэг тэрбум нэг зуун гучин хоёр сая зургаан зуун арван долоон сая долоон зуун ерэн/ төгрөгийн орлогын 16 гүйлгээ, 40 удаагийн 585,523,393.00 /таван зуун наян таван сая таван зуун хорин гурван мянга гурван зуун ерэн гурван/ төгрөгийн зарлагын 40 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралт "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2.10-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд иж бүрэн, үнэн зөв байршуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Усны газрын дарга /З.Батбаяр/, ахлах нягтлан бодогч /Д.Алтантуяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Т.ОДОНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 340/А0150079

Улаанбаатар хот

САГ - 2026/244/НА - СТА - ТЛЦЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Усны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Итали улсад "Усны үнэ цэнэ" гэсэн хуралд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 2 албан хаагчид 16,423,900.00 /арван зургаан сая дөрвөн зуун хорин гурван мянга есөн зуун/ төгрөгийн зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-д "хариуцлагатай байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Усны газрын дарга /З.Батбаяр/, ахлах нягтлан бодогч /Д.Алтантуяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Т.ОДОНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 341/АД150079

Улаанбаатар хот

САГ - 2026/244/НА - СТА - ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Усны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар сонгон шалгаруулсан 1 төсөл арга хэмжээний 1,123,045,000.00 /нэг тэрбум нэг зуун хорин гурван сая дөчин таван мянган/ төгрөгийн гэрээг байгуулахдаа 33,750,000.00 /гучин гурван сая долоон зуун тавин мянган/ төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг байршуулаагүй байхад гэрээг байгуулсан буюу гэрээ байгуулснаас 9 хоногийн дараа гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааг байршуулсан байна. Мөн 1 төсөл арга хэмжээний 465,000,000.00 /дөрвөн зуун жаран таван сая/ төгрөгийн гэрээг байгуулахдаа 13,950,000.00 /арван гурван сая есөн зуун тавин мянган/ төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг гаргуулан аваагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6-д "Дараах нөхцөлийн аль нэг үүссэн бол захиалагч тендерийн баталгааг улсын орлого болгоно", 14.6.2-т "гэрээ байгуулах эрх авсан оролцогч тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу гэрээ байгуулах, эсхүл гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх үүргээ хэрэгжүүлээгүй", 42 дугаар зүйлийн 42.1-д "Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана.", 42.2-т "Захиалагч гүйцэтгэлийн баталгааны дүнг тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувиар тогтоож тендер шалгаруулалтын баримт бичигт тусгана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гүйцэтгэлийн баталгааг гаргуулан аваагүй гэрээ байгуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Усны газрын дарга /З.Батбаяр/, ахлах нягтлан бодогч /Д.Алтантуяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Т.ОДОНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 342/А0150079

Улаанбаатар хот

САГ-2026/244/НА - СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Усны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлахдаа Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/08 дугаар тушаалаар баталсан хөрөнгө оруулалтын 3 төсөл арга хэмжээг 660,090,000.00 /зургаан зуун жаран сая ерэн мянган/ төгрөгөөр илүү тусгасан. Тайлант онд төлөвлөгөөнд 4 удаа өөрчлөлт оруулсан бөгөөд сүүлийн 2 төлөвлөгөөг батлахдаа 2025 оны 5 дугаар сарын 23-ны өдөр 1,125,000,000.00 /нэг тэрбум нэг зуун хорин таван сая/ төгрөгөөр цахимд зарлаж, 1,123,000,000.00 /нэг тэрбум нэг зуун хорин гурван сая/ төгрөгөөр гэрээ байгуулсан 1 ажлыг 1,099,200,000.00 /нэг тэрбум ерэн есөн сая хоёр зуун мянган/ төгрөг буюу 25,800,000.00 /хорин таван сая найман зуун мянган/ төгрөгөөр бууруулан баталсан. Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авахаар төлөвлөсөн 693,946,200.00 /зургаан зуун ерэн гурван сая есөн зуун дөчин зургаан мянга хоёр зуун/ төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ, харьцуулалтын аргаар худалдан авахаар төлөвлөсөн 35,692,000.00 /гучин таван сая зургаан зуун ерэн хоёр мянган/ төгрөгийн 1 төсөл, арга хэмжээг тус тус шууд худалдан авалт хийсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно", 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Усны газрын дарга /З.Батбаяр/, ахлах нягтлан бодогч /Д.Алтантуяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Т.ОДОНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-58 Docx

1526180721



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 343/А0150079

Улаанбаатар хот

САГ - 2026/244/НА - СТА - ТИЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Усны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 129 харилцагчид үйлчилгээ үзүүлсний орлогын төлбөрийн баримтыг 50,416,951.00 /тавин сая дөрвөн зуун арван зургаан мянга есөн зуун тавин нэгэн/ төгрөгөөр дутуу, 112 харилцагчид 125,899,672.00 /нэг зуун хорин таван сая найман зуун ерэн есөн мянга зургаан зуун далан хоёр/ төгрөгийн төлбөрийн баримтыг илүү шивж олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2-д "хэрэглэгчийн системийн дамжуулсан мэдээллийг үндсэн системийн санд бүрэн, үнэн зөв нэгтгэх, эрх бүхий этгээдэд тайлагнах", 17.3.1-т "албан татвар төлөгчийн хийсэн төлбөр тооцооны мэдээллийг хэрэглэгчийн системд төлбөр хийсэн тухай бүр бүртгэнэ", 17.3.2-т "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно", 17.5-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримт олгохоос татгалзах, хуурамч буюу хийгдсэн төлбөр тооцооноос өөр дүнтэй төлбөрийн баримт олгохыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар"-ын "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн

ШААРДАХ нь:

1. Төлбөрийн баримтыг илүү, дутуу шивж олгодог зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Усны газрын дарга /З.Батбаяр/, ахлах нягтлан бодогч /Д.Алтантуяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Т.ОДОНЧИМЭГ